



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2018 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 01022

Улаанбаатар хот

Мэдээллийн технологийн зохицуулах зөвлөлийн  
бүрэлдэхүүнийг шинэчлэн томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын 2015 оны А/838 дугаар тушаалаар Мэдээллийн технологийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийн технологийн тоног төхөөрөмжүүдийн ашиглалтыг сайжруулах, оновчтой зохион байгуулах зорилгоор байгуулагдсан Мэдээллийн технологийн зохицуулах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн томилсугай.

Дарга:	П.Гантөгс	Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын хэлтсийн үйлдвэрлэл хариуцсан менежер
Нарийн бичгийн дарга:	Х.Баттулга	Техник хангалт, навигацийн үйлчилгээний албаны ерөнхий инженер
Гишүүд:	П.Нарантуяа	Техник хангалт, навигацийн үйлчилгээний албаны холбооны хэсгийн ахлах инженер
	Г.Нандин-Эрдэнэ	Техник хангалт, навигацийн үйлчилгээний албаны холбооны хэсгийн инженер
	А.Ванданмагсар	Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албаны мэдээлэл технологийн хэсгийн дарга
	О.Пүрэвзул	"Чингис хаан" Олон улсын нисэх буудлын Теле мэдээлэл холбооны албаны дарга

2. Энэ тушаал гарсантай холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2015 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/838 дугаар тушаалын 1 дэх заалтыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН